

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ

Г.БАЛЖИННЯМ



Огноо: 2020.03.27



**“ДҮТ-ДЦС-3 ХООРОНД ХОЛБООНЫ ХУДАГ, СУВАГЧЛАЛЫН АЖИЛ”**

**ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн дугаар: ДҮТ-2020-01-01**

**Тендер шалгаруулалтын дугаар: ДҮТ/202001001**

Улаанбаатар  
2020 он



**Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Диспетчерийн үндэсний төв ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “ДҮТ-ДЦС-3 ХООРОНД ХОЛБООНЫ ХУДАГ, СУВАГЧЛАЛЫН АЖИЛ” худалдан авах бөгөөд нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар** ирүүлнэ.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр 10 цаг 30** минутад нээнэ.

Тендерийн нээлтэд сонирхсон этгээд оролцох эрхтэй бөгөөд тендерт оролцогч системд нэвтрэн орж тендерийн нээлттэй танилцах эрхтэй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хан – Уул дүүрэг, 3 хороо, Чингисийн өргөн чөлөө,  
Засгийн газрын 14 –р байр, Диспетчерийн үндэсний төв ХХК,  
Утас: 70041371-203**



## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:



- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь дараах мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Компанийн танилцуулга</li> <li>✓ Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>✓ Татварын тодорхойлолт /өргүй байх/</li> <li>✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>✓ Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /2018, 2019 онд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн (гэрээ хүлээлцсэн) акт/</li> <li>✓ Сүүлийн хоёр жилийн /2018, 2019/ аль нэг жилд борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байх.</li> <li>✓ Сүүлийн хоёр жилийн /2017, 2018/ баталгаажсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт</li> <li>✓ Үнийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. /Маягт №ТШМ-2А, Б, В-ээс тохирохыг сонгох/</li> <li>✓ Нийлүүлэх барааны загвар, зураг, тодорхойлолт ирүүлэх</li> <li>✓ Баталгаат засварын хугацаа нэгээс доошгүй жил байна.</li> <li>✓ Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон "Б" ангиллын тусгай зөвшөөрөлтэй байх /Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ (Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар)/</li> </ul> <p><b>Жич:</b> Шалгуур үзүүлэлтийн дагуу материалыг дугаарлаж ирүүлнэ үү.</p> <p>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Хан-Уул дүүрэг, 3- хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын байр 14-р байр, Диспетчерийн үндэсний төв ХХК</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>4 давхар, 404 өрөө</i></p> <p>Огноо: <i>2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Хан-Уул дүүрэг, 3- хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын байр 14-р байр, Диспетчерийн үндэсний төв ХХК</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>4 давхар, 404 өрөө</i></p> <p>Огноо: <i>2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i></p>



## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### ДҮТ - ДЦСЗ ХООРОНД ХОЛБООНЫ ХУДАГ СУВАГЧЛАЛЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

#### Техникийн даалгавар боловсруулах үндэслэл:

1. “ДҮТ - ДЦСЗ хооронд холбооны худаг сувагчлалын их засвар ажил” нь компанийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан.
2. ДҮТ - ДЦСЗ ТӨХК хүртэл газар доогуурхи холбооны худаг, сувагчлал нь эвдэрч, битүүрсэн, шинээр кабель сүвлэх, техникийн үйлчилгээ хийх боломжгүй болсон.
3. ДҮТ - ДЦСЗ ТӨХК хүртэл газар доогуурхи холбооны сувагчлалын худгийн хүзүү, тагийг нээх, хаах, түгжих боломжтой болгож ашиглалтын түвшинг сайжруулах
4. ДҮТ – ДЦСЗ хооронд 24 корын сувагчлалын шилэн кабель шинээр суурилуулж, мэдээлэл дамжуулах боломжийг нэмэгдүүлэх.

#### Холбооны худаг, сувагчлалын одоогийн байдал:

1. ДҮТ ХХК –ийн байрнаас ДЦСЗ ТӨХК хүртэл газар доогуурхи холбооны худаг сувагчлал нь 1986 онд анх ашиглалтанд орсон. Сувагчлал нь 1.0-1.2 метрийн газрын гүнд абцесто цементэн 2 эгнээ, 110 мм хоолойтой, нийт 40 (Худгийн дугаар №23-аас №63 хүртэл) ширхэг дунд зэргийн стандартын худагтай. Худаг хоорондын нисэлтийн зай 19 - 140 метр. Холбооны сувагчлалын трассын дэлгэрэнгүй (М1:1500) зургийг хавсралт-1 ээс үзнэ үү.



ДҮТ-ДЦСЗ хооронд холбооны худаг, сувагчлалын тойм зураг.

2. Нийт холбооны худгийн тагууд нь 10мм–ийн зузаантай төмөр лист төмрөөр тагласан. Төмөр лист таганд гаргасан 25мм-ийн диаметртэй 4 нүхээр худгийн дотор талын төмөр хийцэд гагнаж бэхэлсэн 20мм –ийн диаметртэй арматур төмрийг гарган гагнаж нээгдэхгүй болгож бэхэлж гагнасан. Худгийн таган дээр 1200x1200x150мм хэмжээтэй бетон цутгаж битүүмжлэгдсэн байна.

#### Ажлын техникийн даалгавар:

1. “ДҮТ - ДЦСЗ хооронд одоо байгаа 40 ш холбооны худгуудын тагийг нээх. Худгийн тагийг нээхийн тулд зөөврийн гагнуурын аппарат ашиглах.
2. Холбооны худагт хуримтлагдсан хог, шороо, усыг цэвэрлэх.
3. ДҮТ – ДЦСЗ хооронд одоо байгаа 40 ш холбооны худгуудийн хооронд сүмбэ сүвлэж эвдэрч гэмтсэн, засварлах шаардлагатай сувагчлалын цэгийг тодорхойлох.



4. Ажлын техникийн даалгаврын 3-т заасан гэмтлийн цэг болон хавсралт-1 (ДҮТ-ДЦС3 хооронд худаг, сувагчлалын трассын схем-1,2,3,4,5,6,7) заасан гэмтэлтэй байгаа газрын гүнд 1-1.2 метрийн гүнд хөрсөнд дарагдаж эвдэрсэн абцесто цементон 110мм-ийн 2 эгнээ яндангийн гэмтлийг засварлаж сэргээх, хэвийн ажилд оруулах.
5. ДҮТ-н серверийн өрөөнөөс -ДЦС3 –н ИХБ3-н релений өрөө хүртэл засвар хийж, сэргээсэн сувагчлалаар 24 корын сувагчлалын шилэн кабелийг сүвлэх, суурилуулах. Шинээр татсан кабельд нэг худаг алгасаад худаг дотор кабелийн “ДҮТ ХХК” гэсэн төмөр бирк буюу тэмдэглэгээ хийх.
6. “ДҮТ - ДЦС3 хооронд одоо байгаа 40 ш холбооны худгуудын тагыг нээх, хаах боломжтойгоор түгжээ хийх. (Төмөр нугастай, болт, гайкаар чангалах боломжтой байх, гүйцэтгэгч нь захиалагчид тохиролцож өөр оновчтой хувилбараар шийдвэрлэж болно.)
7. ДҮТ ХХК-ийн серверийн өрөө, ДЦС3 ТӨХК-ийн ИХБ3-н релейний өрөөний байрлах раканд FDF байрлуулж 24 корын шилэн кабелийг цэнэглэх. FDF дээр тодорхой нэр, хаяг бүхий биржжүүлэлтийг хийнэ.
8. 24 корын шилэн кабель 2 чиглэлтэй хэмжилт хийж протокол үйлдэх.
9. Холбооны сувагчлалын трассын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
  - 9.1 Трассын схем.7-р хуудас.1.26-р худгаас урагш ойролцоогоор 26 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн.
  - 9.2 Трассын схем.6-р хуудас.2.27-р худгаас урд талд ойролцоогоор 1 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн.
  - 9.3 Трассын схем.6-р хуудас.3.27-р худгаас баруун талд ойролцоогоор 1 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн.
  - 9.4 Трассын схем.6-р хуудас.4.27-р худгийн бетон таг, хүзүү, таг эвдэрсэн.
  - 9.5 Трассын схем.6-р хуудас.5.31-р худгаас зүүн талд ойролцоогоор 43 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн.
  - 9.6 Трассын схем.5-р хуудас.6.36-р худгийн төмөр таг байхгүй.
  - 9.7 Трассын схем.5-р хуудас.7.37,38-р худгийн дунд сувагчлалд шавар, ус нэвтэрч орсон.
  - 9.8 Трассын схем.4-р хуудас.8.42-р худаг шороонд дарагдаж харагдахгүй болсон.
  - 9.9 Трассын схем.4-р хуудас.9.43-р худгаас урд талд ойролцоогоор 20 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн.
  - 9.10 Трассын схем.4-р хуудас.10.43-р худаг шороонд дарагдаж харагдахгүй болсон.
  - 9.11 Трассын схем.3-р хуудас.11.46-р худгаас урд талд ойролцоогоор 2 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн.
  - 9.12 Трассын схем.2-р хуудас.12.56-р худгийн төмөр таг байхгүй.
  - 9.13 Трассын схем.1-р хуудас.13.59-р худгаас баруун талд ойролцоогоор 9 метрд 2 яндантай сувагчлал эвдэрсэн.
  - 9.14 Трассын схем.1-р хуудас.14.62,63-р худгуудын дунд сувагчлал мордуулан шинэ жижиг худаг (ШХ-1) хийх.
  - 9.15 Трассын схем.1-р хуудас.15 Шинэ худаг ШХ-1 одоо байгаа 63-р худгийн хооронд 19 метрийн урттай 2 эгнээ, 110 мм-н PVC хоолой бүхий сувагчлалыг шинээр хийх.
  - 9.16 Трассын схем.1-р хуудас.16 ДЦС3-н өндөр даралтын хэсгийн барилгын 1 давхарт байрлах холбооны өрөөгөөр дамжуулан уг барилгын зоорийн давхрын кабелийн сувагчлалаар шилэн кабелийг суурилуулна.
  - 9.17 Трассын схем.1-р хуудас.17. Өндөр даралтын хэсгийн барилгаас ЦДҮС ТӨХК-ийн ИХБ3 хүртэл агаараар байрлуулсан кабелийн сувагчлалаар шилэн кабелийг татаж суурилуулна.
  - 9.18 Трассын схем.1-р хуудас.18. ЦДҮС ТӨХК-ийн ИХБ-3 –ийн оролтын худгаар дамжуулан релений өрөөнд байрлах ДҮТ ХХК-н эзэмшлийн 47U-н шүүгээнд байрлуулах 24 портын FDF-г шилэн кабелийг холбоно.



**Бусад техникийн стандарт шаардлагууд:**

1. Гүйцэтгэгч нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгогдсон Монгол улсын нутаг дэвсгэрт харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх. Үүнд: “Гадна холбооны кабель шугамын угсралт, суурилуулалт, засвар” хийх “Б” ангиллын тусгай зөвшөөрөлтэй байна.
2. Гүйцэтгэгч нь угсралтын ажлыг эхлэхээс өмнө ДҮТ ХХК-ийн Мэдээллийн технологи холбооны албаны АТС, шилэн кабелийн инженерээр хянуулж, зөвшөөрөл авсан байна.
3. Шилэн кабелийн угсралтын ажлыг гадна агаарын температур -5 градусаас илүүгүй хүйтний нөхцөлд гүйцэтгэх.
4. Тоног төхөөрөмжийн ажиллах баталгаат хугацаа нь 2 тал акт үйлдэн хүлээлцсэн өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай байх бөгөөд энэ хугацаанд холбооны худаг, сувагчлалд гэмтэл гарсан үед гүйцэтгэгч нь өөрийн зардлаар засварлаж хэвийн ажилд оруулах арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
5. Гүйцэтгэгч нь угсралт, суурилуулалт, засварын ажлыг бүрэн дууссаны дараа техникийн ажлын хүлээлцсэн акт, гүйцэтгэлийн зураг, холбогдох бичиг баримтыг боловсруулан захиалагчид хүлээлгэн өгнө.
6. Захиалагч нь худаг, сувагчлалын засварын ажилд хамтран оролцож, дэмжлэг үзүүлнэ.
7. Гүйцэтгэгч нь зайлшгүй тохиолдолд тоног төхөөрөмжийг суурилуулах явцад ажлын тоо хэмжээнд ороогүй боловч тооцоолоогүй зардлыг харилцан тохиролцсон үндсэн дээр хариуцна.
8. Гүйцэтгэгч нь цахилгаан тоног төхөөрөмжинд ажил гүйцэтгэх инженер техникийн ажилтнуудынхаа аюулгүй ажиллагааны группын үнэмлэх, түүний үнэн зөв болохыг, группын зэрэг нь гүйцэтгэх ажлын цар хэмжээтэй тохирч байгаа эсэх болон ИТА-уудынхаа аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
9. Гүйцэтгэгч нь эрчим хүч, харилцаа холбооны барилга байгууламж ажилд орохдоо “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг чанд мөрдөн ажиллана.
10. Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй байгаа эрх бүхий хуулийн этгээд нь холбооны худаг, сувагчлалтай танилцах зорилгоор ажлын байран дээр өөрийн биеэр ирж танилцаж болно.
11. Холбооны инженерийн байгууламжийн угсралт суурилуулалтын ажлыг Монгол улсын Телефон сүлжээний кабелийн худаг.Техникийн ерөнхий шаардлага. MNS5016:2001, Телефон сүлжээний сувагчлалд зориулсан хуванцар яндан.MNS 5017:2001, Шилэн кабелийн залгаа хийх, муфьтлэх. Ерөнхий шаардлага.MNS 5278:2014 стандартуудыг баримтлан хийж гүйцэтгэнэ.


**Шаардлагатай холбооны худаг, сувагчлалын материалын жагсаалт, техникийн шаардлага:**

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Маяг	Нэгж	Тоо	Техникийн үзүүлэлт, шаардлагууд
1	PVC хоолой	110мм, 2м	ш	50	PVC хананы зузаан 4 мм-ээс багагүй байх
2	Элс	-	тн	3	Уулын элс
3	Холбооны жижиг худаг	1000x1000x1000	ш	1	ДЦСЗ ТӨХК-ийн хашаанд суурилуулна.
4	Боолт, гайк	16мм	ком	42	
5	Төмөр нугас	-	ш	42	
6	Шилэн кабель	24C, G652D	м	3900	
7	Төгсгөлийн хайрцаг	FDF	ш	2	FC,24порт, 1U, Rackmount, pigtail cable
8	Бусад	-	ком	1	Ажлын техникийн даалгаврын 9-д заасан ажлуудтай холбоотой гарч болох материалуудыг тооцоолох

ХХК  
ХУУДАС  
БАТАЛГААЖУУЛАВ




Тав. 3УРАГ



# 2


ДҮТ - ДЦСЗ хооронд худаг, сувагчлалын трассын схем-2



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ХХК  
**ХУУДАС**  
**БАТАЛГААЖУУЛАВ**



# 3

ДҮТ - ДЦСЗ хооронд худаг, сувагчлалын трассын схем-3



# 4

ДҮТ - ДЦСЗ хооронд худаг, сувагчлалын трассын схем-4



10 43-р худаг шороонд шороонд дарагдсан харагдахгүй.


9 43-р худагас урагшаа ~20 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн

8 42-р худаг шороонд шороонд дарагдсан харагдахгүй

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ХХК  
**ХУУДАС**  
**БАТАЛГААЖУУЛАВ**

# 5

ДҮТ - ДЦСЗ хооронд худаг, сувагчлалын трассын схем-5



# 6



ДҮТ - ДЦСЗ хооронд худаг, сувагчлалын трассын схем-6

27-р худгийн бетон таг, хүзүү, таг эвдэрсэн ④

27-р худгийн баруун талд ~1метр 2 яндантай сувагчлал эвдэрсэн ③

27-р худгийн урд талд ~1метр 2 яндантай сувагчлал эвдэрсэн ②

31-р худгийн зүүн талд ~43 метрт 2 яндантай сувагчлал эвдэрсэн ⑤




ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ХХК  
**ХУУДАС**  
**БАТАЛГААЖУУЛАВ**

# 7




ДҮТ - ДЦСЗ хооронд худаг, сувагчлалын трассын схем-7

Түгжүүр схем:



① 26-р худагас урагш ~26 метрт  
2-яндантай сувагчлал эвдэрсэн



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ХХК  
**ХУУДАС**  
**БАТАЛГААЖУУЛАВ**

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**  
**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

*Диспетчерийн Үндэсний Төвийн гүйцэтгэх захирал Г.Балжинням танаа*

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:





МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

(А ангилал)

Огноо: \_\_\_\_\_  
 НТШ-ын дугаар: \_\_\_\_\_  
 Тендерийн урилгын дугаар: \_\_\_\_\_  
 Хувилбарт тендерийн дугаар: \_\_\_\_\_  
 Хуудасны \_\_\_\_\_-ын \_\_\_\_\_ дугаар \_\_\_\_\_

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXWбүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 15.9.(а).(3)-д шаардсан бол)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэхувь	ТӨӨЗ-ны 15.9(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9)
<b>Тендерийн нийт үнэ (10)</b>									

ДИС ТЕНДЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
 ХХК  
**ХУУДАС**  
**БАТАЛГААЖУУЛАВ**

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Огноо: \_\_\_\_\_  
 НТШ-ын дугаар: \_\_\_\_\_  
 Тендерийн урилгын дугаар: \_\_\_\_\_  
 Хувилбарт тендерийн дугаар: \_\_\_\_\_

(Б ангилал)

Хуудасны \_\_\_\_\_-ын \_\_\_\_\_

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	ТӨӨЗ-ны 15.9(б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэрж үнэ	Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 x 5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТӨӨЗ-ны 15.9(б).(3)-д шаардсан бол)	ТӨӨЗ-ны 15.9(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8)
<b>Тендерийн нийт дүн (9)</b>								

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨӨР  
 ХХК  
**ХУУДАС  
 БАТАЛГААЖУУЛАВ**

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Огноо: \_\_\_\_\_  
НТШ-ын дугаар: \_\_\_\_\_  
Тендерийн урилгын дугаар: \_\_\_\_\_  
Хувилбарт тендерийн дугаар: \_\_\_\_\_

(В ангилал)

Хуудасны \_\_\_\_\_ -ын \_\_\_\_\_

ТӨӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо	Тоо ширхэг	ТӨӨЗ-ны 15.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ	ТӨӨЗ-ны 15.9(в). (2)-д заасан нэр төрөл бүрт төлсөн гаалийн болон импортын татвар хураамж [ноглох бичиг баримтыг үндэслэнэ]	ТӨӨЗ-ны 15.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7)	ТӨӨЗ-ны 15.9 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (ТӨӨЗ-ны 15.9(в) (5)-д шаардсан бол)	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11)
<b>Тендерийн нийт үнэ (12)</b>											

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ХХК  
**ХУУДАС  
БАТАЛГААЖУУЛАВ**

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх
  2. Төслийн менежерийн шийдвэр
  3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх
  4. Аюулгүй байдал
  5. Зааварчилгаа
  6. Маргааныг шийдвэрлэх
- 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
  - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
  - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
  - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
  - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
  - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
  - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

### Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. Ажлын хөтөлбөр
  8. Зөрчил, гологдол илрүүлэх
  9. Зөрчил, гологдол арилгах
- 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
  - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
  - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
  - 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
  - 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.



10. Зөрчил, гологдол арилгахгүй байх
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. Алданги
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.



- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.


ХХК  
ХУУДАС  
БАТАЛГААЖУУЛАВ

### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>ДҮТ-ДЦС-3 хооронд холбооны худаг, сувагчлалын ажил, ДҮТ-2020-01-01</i>
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>ДҮТ ХХК-ийн МТХА-ны ахлах мэргэжилтэн Д.Нацагдорж</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>2020 оны 5 дугаар сарын 01-ний өдөр</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>2020 оны 6 дугаар сарын 01-ний өдөр</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>10</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>365</i> хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>0,5</i> байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>10</i> байна.
ГЕН 16.1	Гэрээний үнийн дүнгийн <i>95</i> хувийг ажил хүлээн авсан акт болон төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш ажлын <i>5</i> хоног дотор төлнө  Баталгаат засварын хугацаанд ашиглалтын найдваржилтыг хангуулах, хянах зориулалтаар бараа хүлээн авснаас хойш <i>1</i> жилийн хугацаанд гэрээний үнийн дүнгийн <i>5</i> хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг захиалагч авч үлдэх ба бараа хүлээн авснаас хойш <i>1</i> жилийн дараа нийлүүлэгчид эргүүлэн төлнө.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг <i>2020 оны 06 дугаар сарын 01-ний</i> дотор гаргаж өгнө.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.



## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;





- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :  
5.9. Санхүүжилтийн хуваарь;  
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

